

# Үүргийн дэвтэр

## Төслийн нэр

Төсөл: Төслийн нэр Хувилбар

Зохиогч: Санлигийн Бадрал

Вэб: <http://bolorcms.com/badaa>

Сүүлчийн Өөрчилөлт: May 10, 2007

## Гарчиг

<b>1</b>	<b>Зорилгын тодорхойлолт</b>	<b>3</b>
1.1	Системд оролцогчид . . . . .	3
<b>2</b>	<b>Бүтээгдэхүүний хэрэглээ</b>	<b>4</b>
<b>3</b>	<b>Бүтээгдэхүүний үйл ажиллагаа</b>	<b>5</b>
3.1	Системийн функционал тодорхойлолтуудыг энд оруулна уу . . . . .	5
3.1.1	Хэрэглэгч бүртгүүлэх болон нэвтрэх функц . . . . .	5
<b>4</b>	<b>Бүтээгдэхүүний өгөгдөлүүд</b>	<b>6</b>
<b>5</b>	<b>Бүтээгдэхүүний шинж чанар</b>	<b>7</b>
5.1	Систем ба системийн орчин . . . . .	7
5.2	Функционал бус шаардлагууд . . . . .	7
<b>6</b>	<b>Чанарын шаардлагууд</b>	<b>8</b>
<b>7</b>	<b>Нэмэлт</b>	<b>9</b>
7.1	Хэрэгжүүлэлт . . . . .	9
7.2	Цаашид яаж өргөтгөж болох эсэх . . . . .	9

# 1 Зорилгын тодорхойлолт

Энэ програм хангамжийг хэрэглэсэнээр ямар зорилгод хүрэх ёстой вэ?

Энэ хэсэгт үндсэн даалгаварыг тодорхойлон бичнэ. Үүнийг ихэнх тохиолдолд даалгавар олгогч бэлтгэчихсэн байдаг тул хуулаад тавихад хангалттай. Энэ хэсэгт та өөрийн зүгээс системд хэн хэн оролцохыг тодорхойлчих хэрэгтэй. Хэн хэн энэ системийг хэрэглэх юм? Тэд хэр зэрэг туршлагатай вэ? гэх мэт.

Жишээлбэл. Интернетээр номын худалдаа хийх боломж бүхий портал сайт хийх төсөл авъя.

Дурын хэрэглэгч интернетээр ном худалдан авах боломж олгоно.

## 1.1 Системд оролцогчид

- *Вэб мастер*  
Вэб мастер вэбийн дизайн болон агуулгыг хариуцаж ажиллана.
- *Хэрэглэгч*  
Хэрэглэгч. Дургийн хэрэглэгч энэ системийг ашиглан ном худалдан авах боломжтой.

## 2 Бүтээгдэхүүний хэрэглээ

Энэ програм хангамж ямар хэрэглээний хүрээнд хэнд зориулагдсан бэ?

Энэ хэсэгт хөгжүүлэх системийн хэрэглээний хүрээ хязгаарыг тодорхойлох хэрэгтэй байдаг. Тухайн газрын мэргэжилийн ухагдахуунуудыг оруулан ихэнх тохиолдолд зураг оруулж ирж дүрсэлбэл зохимжтой харагддаг. Байгууллагын бизнес процессийг тодорхойлон хаана төслын ямар хэсэг тохирохыг тоочих хэрэгтэй.

Жишээ нь:

Энэ програм хангамж нь Болор-АУС компаны хэрэглээнд зориулагдсан. Системийн зохион байгуулагчид болон вэб мастерууд системийг удирдан сайжруулах ёстой.

Энэхүү систем нь дэлхий дахинаа хэрэглэгдэх боломжтой тул үндсэн хэл **Англи** байх ба монгол хэл дээр мөн хийгдэх ёстой. Цааш янз бүрийн хэл нэмэгдэх боломжтой модульчлагдсан байх ёстой. ...

### 3 Бүтээгдэхүүний үйл ажиллагаа

Бүтээгдэхүүний үндсэн функц үйл ажиллагаа даалгавар өгөгчийн зүгээс юу юу вэ?

Энэ хэсэгт хөгжүүлэх системийн үндсэн функц, үйл ажиллагааг нарийвчилан тодорхойлох хэрэгтэй. Функционал шаардлага гэж англи литературууд дээр тэмдэглэсэн байгаа. Энэ хэсэгт ерөнхий Use Case диаграмыг оруулж ирж болно. Мөн нээлттэй, бүрхэг асуултуудыг энд оруулах хэрэгтэй бөгөөд эцсийн хувилбар дээр хоосон байх хэрэгтэй. Харин завсарын хувилбарууд дээр маш их утга учиртай, хэрэгтэй байдаг.

#### 3.1 Системийн функционал тодорхойлолтуудыг энд оруулна уу

Жишээлбэл:

##### 3.1.1 Хэрэглэгч бүртгүүлэх болон нэвтрэх функц

Системийг хэрэглэхийн тулд хэрэглэгч бүртгүүлсэн бөгөөд нэвтэрсэн байх ёстой.

**/LF0010/ Дурын хэрэглэгч системд доор дурьдсан мэдээллийг оруулсанаар бүртгүүлэх боломжтой**

- өөрийн хэрэглэгчийн нэр,
- хүссэн нууц үг ба
- бусад хувийн өгөгдөл.

Үүний дараа хэрэглэгч нэвтрэх боломжтой болох ба

**/LF0020/ Хэрэглэгч системд доорх мэдээлэлийг оруулж нэвтэрнэ**

- түүний хэрэглэгчийн нэр ба
- түүний нууц үг.

**/LF0030/ Нэвтэрсэн хэрэглэгч цаг үргэлж гарах боломжтой.**

Хэрэглэгчидийн эрх бүлэглэгдсэн байж болно. Жишээлбэл найдвартай хэрэглэгч, найдваргүй хэрэглэгч ч гэдэг юм уу.

## 4 Бүтээгдэхүүний өгөгдөлүүд

Бүтээгдэхүүний үндсэн өгөгдөлүүд даалгавар өгөгчийн зүгээс юу юу вэ?

Энд програм хангамжийн ажиллах үндсэн өгөгдөлүүд оруулж ирнэ. Жишээлбэл:

*(Дор хаяж)* дараах өгөгдөлүүд тогтмол хадгалагдах ёстой.

**/LD100/ Хэрэглэгчийн өгөгдөл:** Хэрэглэгчийн хувийн мэдээлэл:

- Хэрэглэгчийн нэр
- Нууц үг (түлхүүрлэгдсэн)
- Имэйл хаяг
- **Бусад хувийн мэдээлэл**
- Төвшин. Найдвартай хэрэглэгч үү?
- Бүртгүүлсэн огноо
- Сүүлд нэвтэрсэн огноо
- **Хувийн тохиргоо**

**/LD110/ Хувийн өгөгдөл** Бусад хувийн мэдээлэлд дараах зүйлс хамаарна:

- Цол
- Нэр
- Овог
- Омог
- Хаяг
- Утас
- Вэб
- Фото
- Хаяг
- Мэргэжил
- Нас

**/LD120/ Бусад өгөгдөлүүдийг та дээрх жишээтэй төстэй оруулна уу**

## 5 Бүтээгдэхүүний шинж чанар

Бүтээгдэхүүний бусад шинж чанарууд юу вэ?

Энэ хэсэгт хөгжүүлэх системийн өмнөх хэсэгт заагдсан үйл ажиллагаанд хамаараагүй шинж чанаруудыг оруулна. Үүнд бүтээгдэхүүний хэрэглэгдэх системийн орчин болон функционал бус шаардлагууд орно. Энэ хэсэг хэдийчинээ тодорхой байна бүтээгдэхүүнийг тестлэх орчинг бүрдүүлэхэд төдийчинээ сайн байдаг.

### 5.1 Систем ба системийн орчин

Жишээлбэл энэ бүтээгдэхүүн интернет, интранет ажиллах ёстой. Үйлдлийн системээс үл хамааран бүх төрлийн персонал компьютер, соларис серверүүд дээр ажиллана. Мөн нэмэлт гүйх-цагийн горимыг тодорхойлно. Ямар ямар сан хэрэглэгдэх вэ?

### 5.2 Функционал бус шаардлагууд

Хугацаа, өгөгдөл, нарийвчилалтай хамааран ямар ямар зүйлс ямар тодорхой функцүүд дээр хэрэгтэй вэ?

Энэ дэд хэсэгт бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэхийн тулд ямар ямар шинж, чанаруудыг тодорхойлж оршин буй өөр төстэй системүүдтэй харьцуулж болно.

*/LL200/ Найдвартай байдал:* Хэрэглэгчийн оруулж болох бүх өгөгдөлийг хянах.

*/LL210/ Тогтвортой байдал:* Хэрэглэгчийн буруу үйлдэлд анхааруулга өгч засварлах боломжоор хангаж өгөх, зөвлөмж өгөх.

*/LL220/ Хуулийн шаардлага:* Ямар стандарт ямар хуулийн шаардлагыг хангах эсэх. Жишээлбэл: Бүтээгдэхүүн **ISO 9000** стандартыг хангах ёстой.

*/LL230/ Арчилгааны шаардлага:* Жишээ нь: Цааш хөгжүүлэхэд хэрэглэгдэх баримтууд бэлгэсэн шаардлагатай байх. Ирээдүйд бүтээгдэхүүн герман хэл дээр гарах боломжтой байх гэх мэт.

*/LL240/ Үр ашигийн шаардлага:* Жишээ нь: Нэг хуудас 0.5 секундээс хэтрэхгүй хугацаан хийгдэх гэх мэт.

*/LL250/ Хэрэглэгчийн тохь тух:* Хэрэглэгч бүрт өөртөө тохируулах интерфейс бүрдүүлэх боломж эсвэл стандарт интерфейстэй байх эсэх.

## 6 Чанарын шаардлагууд

Ямар ямар чанарын шаардлагуудыг ямар төвшинд хангах ёстой вэ?(Найдвартай байдал, Бат бэх, хэрэгчид таатай орчин, үр ашигтай байдал,...)

Тухайн даалгавар өгөгч ямар ямар эрсдэлийг хүлээж авах чадвараас хамааруулан тодорхойлно. **Тогтвортой байдал** болон **Найдвартай байдал**д хамгийн их анхаарал хандуулна. Хоёрдугаарт **хэрэглэгчийн таатай орчин** болон **үр ашигтай байдал**д анхаарал хандуулах хэрэгтэй.



## 7 Нэмэлт

Өөр ямар онцгой шаардлагууд байна вэ?

### 7.1 Хэрэгжүүлэлт

Програм хангамж заавал **.PHP und POSTGRESQL** ( байгууллагын зардал эсвэл хуучин хэрэглэж байсан орчиноос шалтгаалж болох ) ашиглан бүтэх хэрэгтэй. Найдвартай байдлын үүднээс Cookies хэрэглэхгүй.

### 7.2 Цаашид яаж өргөтгөж болох эсэх

Санал асуулга, хэлэлцүүлэг өрнүүлэх боломж гэх мэт. ...